



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ 2021 ОНЫ ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар хот  
2022 он

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу

Засгийн газрын III байр

Утас: 976-11-326414

Цахим хуудас: [www.nso.mn](http://www.nso.mn)

И-мэйл: [international@nso.mn](mailto:international@nso.mn)

## АГУУЛГА

I. УДИРТГАЛ.....	2
II. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО .....	3
2.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО.....	3
2.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО .....	7
III. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА.....	14
3.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА.....	14
3.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА.....	18
IV. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИН.....	24
4.1 ӨРХИЙН ОРЛОГО БА ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ .....	24
4.2 АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИНГИЙН ОРЛОГО.....	26
V. ТЭГШ БУС БАЙДАЛ .....	26
5.1 ОРЛОГЫН ТЭГШ БУС БАЙДАЛ .....	26
5.2 ЗАРЛАГЫН ТЭГШ БУС БАЙДАЛ .....	27
VI. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ.....	30
6.1 ХАДГАЛАМЖ .....	30
6.2 ЗЭЭЛ .....	31

## I. УДИРТГАЛ

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг улирал тутам явуулах”-аар заасны дагуу судалгааг тогтмол зохион байгуулан явуулж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлохоос гадна өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индекс ашигладаг сагс болон жинг шинэчлэх, ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар тооцоход шаардлагатай мэдээллийг гаргах үндсэн зорилготой улс, бүс, суурьшлын хэмжээнд төлөөлөх чадвартай судалгаа юм.

Уг судалгааны 2021 оны үр дүнг нийтийн хүртээл болгох зорилгоор судалгаанд хамрагдсан 11199 өрхийн мэдээлэлд тооцоолол хийж энэхүү танилцуулгыг бэлтгэлээ.

## II. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО

Өрхийн амьжиргаанд нөлөөлж байдаг гол хүчин зүйлийн нэг нь өрхийн орлого юм.

Өрхийн нийт орлогыг өрхийн мөнгөн орлого, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.


Өрхийн мөнгөн орлого нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

### 2.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО

Судалгааны 2021 оны дүнгээр нэг өрхийн сарын дундаж нийт орлого оны үнээр 1.6 сая төгрөг болж, өмнөх оноос 112.7 (7.5%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Харин үнийн нөлөөллийг арилган 2015 оны үнээр илэрхийлж үзэхэд өрхийн сарын дундаж бодит нийт орлого 1.1 сая төгрөг болж, өмнөх оноос 63.6 (5.3%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 2.1а).

Улсын дунджаар 2021 онд өрхийн сарын дундаж нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 92.5 болж, өмнөх оноос 0.1 нэгж хувиар, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 4.9 болж, 0.8 нэгж хувиар нэмэгдэж, харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 2.6 болж, өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурсан байна (Зураг 2.1б).

ЗУРАГ 2.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр, орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар, улсын дунджаар




Нэг өрхийн сарын дундаж нийт орлого оны үнээр 2021 онд өмнөх оноос хотод 67.9 (4.2%) мянган төгрөг, хөдөөд 201.6 (15.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн орлогын зөрүү 2021 онд өөр хандлагатай болсон байна. Тухайлбал, 2020 оноос өмнө хотын өрхүүдийн нэрлэсэн болон бодит орлого хөдөөгийн өрхүүдтэй харьцуулахад илүү өсөлттэй байсан бол 2021 онд энэ хандлага өөрчлөгдөж хөдөөгийн өрхүүдийн

нэрлэсэн болон бодит орлого илүү эрчимтэй нэмэгдсэн байна. Энэ нь хөдөө аж ахуй эрхэлдэг өрхүүдийн үндсэн орлого болох мал, махаа худалдсан, ноолуураа зарсан орлого өссөн болохыг илтгэж байна.


Үнийн нөлөөллийг арилган 2015 оны үнээр илэрхийлж үзэхэд өрхийн сарын дундаж бодит нийт орлого 2021 онд өмнөх оноос хотод 107.0 (8.2%) мянган төгрөгөөр буурч, харин хөдөөд 21.8 (2.1%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 2.2).

ЗУРАГ 2.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр, хот, хөдөөгөөр



Өрхийн нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2021 онд өмнөх оноос хотод 0.8 нэгж хувиар нэмэгдэж, харин хөдөөд 0.3 нэгж хувиар буурсан байна (Зураг 2.3).

ЗУРАГ 2.3 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, хот, хөдөөгөөр




Нэг өрхийн сарын дундаж нийт орлогыг бүсчилэн<sup>1</sup> харвал, оны үнээр 2021 онд өмнөх оноос Баруун бүсэд 348.0 (24.8%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 243.8 (19.7%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 130.8 (9.4%) мянган төгрөгөөр, Төвийн бүсэд 81.4 (6.2%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ. Үнийн нөлөөллийг арилган тооцсон бодит нийт орлогын хэмжээ өмнөх оноос Баруун бүсэд 112.5 (10.0%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 54.8 (5.5%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин Төвийн бүсэд 66.6 (6.4%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 40.1 (3.6%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 2.4).

ЗУРАГ 2.4 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр, бүсээр



Өрхийн нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2021 онд Баруун бүсэд хамгийн бага буюу 84.3 хувь, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хамгийн өндөр буюу 12.6 хувь байна (Зураг 2.5).


ЗУРАГ 2.5 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, бүсээр



<sup>1</sup> Баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд; Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл; Төвийн бүсэд Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв; Зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд хамрагдана.


Нэг өрхийн сарын дундаж нийт орлого оны үнээр 2021 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 9.8 (0.6%) мянган төгрөгөөр, аймгийн төвд 202.8 (14.6%) мянган төгрөгөөр, сумын төвд 206.8 (16.0%) мянган төгрөгөөр, хөдөөд 206.6 (16.5%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ. Үнийн нөлөөллийг арилган тооцсон бодит нийт орлогын хэмжээ өмнөх оноос Улаанбаатар хотод 158.2 (11.3%) мянган төгрөгөөр буурч, харин аймгийн төвд 11.3 (1.0%) мянган төгрөгөөр, сумын төвд 23.8 (2.3%) мянган төгрөгөөр, хөдөөд 27.3 (2.7%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 2.6).

ЗУРАГ 2.6 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр, суурьшлаар



Өрхийн нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2021 онд хөдөөд хамгийн бага буюу 79.6 хувь, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хамгийн өндөр буюу 18.5 хувь байна (Зураг 2.7).

ЗУРАГ 2.7 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, суурьшлаар






## 2.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО

Улсын дунджаар 2021 онд нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого оны үнээр 1.5 сая төгрөг болж, өмнөх оноос 106.9 (7.7%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг задалвал, цалин хөлсний орлого оны үнээр өмнөх оноос 59.9 (7.9%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 11.8 (13.1%) мянган төгрөгөөр буурч, харин тэтгэвэр, тэтгэмжийн орлого 146.0 (49.5%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 31.9 (28.1%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.


Өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит мөнгөн орлогын хэмжээ 2021 онд 1.1 сая төгрөг болж, өмнөх оноос 56.8 (5.1%) мянган төгрөгөөр буурсан байна. Бодит мөнгөн орлогын хэмжээ өмнөх оноос 5.1 хувиар буурахад цалин хөлсний бодит орлого 113.9 (18.8%) мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 2.8).

ЗУРАГ 2.8 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, мянган төгрөгөөр, улсын дунджаар



Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь 2021 онд өмнөх оноос 7.8 нэгж хувиар, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 1.3 нэгж хувиар буурч, тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 8.2 нэгж хувиар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын эзлэх хувь 1.6 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 2.9).

ЗУРАГ 2.9 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, улсын дунджаар



Тэтгэвэр, тэтгэмжийн орлогыг төрлөөр нь задалж харвал, 2021 онд өмнөх оноос улсын дунджаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод хүүхдийн мөнгөн тэтгэмжийн эзлэх хувь 4.5 нэгж хувиар, бусад тэтгэвэр, тэтгэмжийн эзлэх хувь 4.2 нэгж хувиар нэмэгдсэн нь хамгийн өндөр өсөлт байна (Хүснэгт 2.1).

ХҮСНЭГТ 2.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГОД ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ОРЛОГЫН ЭЗЛЭХ ХУВЬ, тэтгэвэр, тэтгэмжийн зарим нэр төрлөөр


	2018	2019	2020	2021
<b>Тэтгэвэр, тэтгэмжийн орлого</b>	<b>19.4</b>	<b>18.4</b>	<b>21.2</b>	<b>29.4</b>
Өндөр насны тэтгэвэр	12.6	12.2	12.8	12.7
Хүүхдийн мөнгө	2.0	1.8	3.9	8.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	2.4	2.1	2.0	2.0
Жирэмсэн болон амаржсан, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	0.9	0.7	1.1	0.8
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.3	0.4	0.3	0.2
Бусад тэтгэвэр, тэтгэмж*	1.2	1.2	1.1	5.3

Эх үүсвэр: ӨНЭЭС 2018-2021

\* Тайлбар: Засгийн газраас Коронавируст халдварын цар тахлын үед бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхтэй холбогдуулан иргэдийг вакцинжуулах, тэдний орлого, дархлааг дэмжих зорилгоор Монгол Улсын иргэн бүрт 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн мөнгөн дэмжлэгийг нэг удаа олгосон.


Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого оны үнээр 2021 онд өмнөх оноос хотод 80.1 (5.1%) мянган төгрөг, хөдөөд 163.5 (15.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. 2021 онд хөдөөгийн өрхүүдийн мөнгөн орлогын өсөлт хотын өрхүүдээс илүү байжээ. Гэхдээ хот, хөдөөгийн өрхүүдийн дундаж мөнгөн орлогын хэмжээг хооронд нь харьцуулбал, оны үнээр 2021 онд хотын нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого хөдөөгийнхөөс 432.9 (35.6%) мянган төгрөгөөр илүү байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн орлогын энэ зөрүү өмнөх оноос 83.4 мянган төгрөг буюу 13.4 нэгж хувиар буурсан байна. Үнийн нөлөөллийг арилган 2015 оны үнээр илэрхийлж үзэхэд өрхийн сарын дундаж бодит мөнгөн орлого 2021 онд өмнөх оноос хотод 92.5 (7.4%) мянган төгрөгөөр буурч, харин хөдөөд 15.5 (1.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 2.10).

ЗУРАГ 2.10 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, мянган төгрөгөөр, хот, хөдөөгөөр




Хөдөөгийн өрхийн сарын дундаж мөнгөн орлогын дөрөвний нэгийг цалин хөлсний орлого, гуравны хоёрыг тэтгэвэр, тэтгэмжийн орлого болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого бүрдүүлж байгаа бол хотын өрхийн сарын дундаж мөнгөн орлогын тал хувийг цалин хөлсний орлого дангаараа бүрдүүлж байна (Зураг 2.11).

ЗУРАГ 2.11 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, хот, хөдөөгөөр




Өрхийн сарын дундаж мөнгөн орлого оны үнээр 2021 онд өмнөх оноос Баруун бүсэд 284.4 (23.9%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 216.4 (19.7%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 124.4 (10.2%) мянган төгрөгөөр, Төвийн бүсэд 70.9 (6.1%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ. Үнийн нөлөөллийг арилган тооцсон бодит мөнгөн орлогын хэмжээ өмнөх оноос Баруун бүсэд 87.8 (9.2%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 48.7 (5.5%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин Төвийн бүсэд 60.2 (6.5%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 28.0 (2.9%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 2.12).

ЗУРАГ 2.12 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, мянган төгрөгөөр, бүсээр



Өрхийн сарын дундаж мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь 2021 онд өмнөх оноос бүсүүдэд 8.4-10.9 нэгж хувиар буурсан бол тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 6.9-8.1 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 2.13).

ЗУРАГ 2.13 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, бүсээр




Өрхийн сарын дундаж мөнгөн орлого оны үнээр 2021 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 32.2 (1.9%) мянган төгрөгөөр, аймгийн төвд 192.9 (14.6%) мянган төгрөгөөр, сумын төвд 175.1 (15.5%) мянган төгрөгөөр, хөдөөд 191.5 (19.8%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ. Үнийн нөлөөллийг арилган тооцсон бодит мөнгөн орлогын хэмжээ өмнөх оноос Улаанбаатар хотод 136.7 (10.1%) мянган төгрөгөөр буурч, харин аймгийн төвд 10.8 (1.0%) мянган төгрөгөөр, сумын төвд 16.4 (1.8%) мянган төгрөгөөр, хөдөөд 43.6 (5.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 2.14).

ЗУРАГ 2.14 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, мянган төгрөгөөр, суурьшлаар




Өрхийн сарын дундаж мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь 2021 онд өмнөх оноос бүх суурьшилд 2.4-8.5 нэгж хувиар буурсан бол тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 7.0-8.6 нэгж хувиар нэмэгдсэн байна. Хөдөөгийн өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 49.3 хувийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого бүрдүүлж байгаа бол бусад суурьшилд мөнгөн орлогын 42.8-57.7 хувийг цалин хөлсний орлого бүрдүүлж байна (Зураг 2.15).

ЗУРАГ 2.15 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, суурьшлаар




Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг сууцны төрлөөр задлан харвал, оны үнээр 2021 онд улсын дунджаар гэрт амьдардаг өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлого өмнөх оноос 128.3 (12.8%) мянган төгрөгөөр, байшинд амьдардаг өрхүүдийнх 116.7 (8.7%) мянган төгрөгөөр, орон сууцанд амьдардаг өрхүүдийнх 75.3 (3.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 2.16). Хэдийгээр орон сууцанд амьдардаг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын өсөлт 2020-оос 2021 онд бага байгаа ч ерөнхий дүнгээрээ гэрт амьдардаг өрхийн сарын дундаж мөнгөн орлогоос бараг 2 дахин их, байшинд амьдардаг өрхийнхөөс 40.2 хувиар илүү байв.

ЗУРАГ 2.16 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, мянган төгрөгөөр, оны үнээр, сууцны төрлөөр



Улсын дунджаар 2021 онд гэрт амьдардаг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 35.5 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 29.6 хувийг цалин хөлсний орлого, 29.5 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 5.4 хувийг бусад орлого эзэлж байна. Харин орон сууцанд амьдардаг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 58.2 хувийг цалин хөлсний орлого, 22.0 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 12.8 хувийг бусад орлого, 7.0 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого эзэлж байна. Сууцны бүх төрөлд мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь өмнөх оноос 4.3-19.4 нэгж хувиар буурсан бол тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 6.0-9.5 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 2.17).

ЗУРАГ 2.17 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, сууцны төрлөөр



Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэн 2015 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлэн харахад, улсын дунджаар 500.0 мянган төгрөг хүртэлх орлоготой өрхийн эзлэх хувь 2021 онд өмнөх оноос 1.0 нэгж хувиар, 500.0-700.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 1.1 нэгж хувиар, 700.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 0.8 нэгж хувиар, 900.0-1100.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 0.2 нэгж хувиар, 1.1-1.6 сая төгрөгийн

орлоготой өрхийн эзлэх хувь 0.2 нэгж хувиар тус тус нэмэгдэж, харин 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 1.1 нэгж хувиар, 2.1-3.0 сая төгрөгийн орлоготой өрхийн эзлэх хувь 1.4 нэгж хувиар, 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн эзлэх хувь 0.8 нэгж хувиар тус тус буурсан байна.

Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэн 2015 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлэн хот, хөдөөгөөр харвал, 2021 онд хотын нийт өрхийн 16.0 хувь, хөдөөгийн нийт өрхийн 32.0 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэлх орлоготой, мөн хотын 22.5 хувь, хөдөөгийн 14.6 хувь нь 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой, хотын 20.2 хувь, хөдөөгийн 10.5 хувь нь 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байна (Хүснэгт 2.2).

ХҮСНЭГТ 2.2 МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

Мөнгөн орлогын бүлэг	Улсын дундаж				Хот				Хөдөө			
	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
300 000 төгрөг хүртэл	12.3	9.5	8.1	8.0	7.4	5.8	4.6	5.4	21.2	16.7	15.0	12.9
300 001 - 500 000	16.4	14.3	12.4	13.5	13.6	11.6	9.3	10.6	21.4	19.5	18.4	19.1
500 001 - 700 000	17.2	17.4	14.7	15.8	16.0	16.4	13.1	13.9	19.4	19.3	17.8	19.4
700 001 - 900 000	14.5	14.2	13.7	14.5	15.6	14.4	13.5	15.1	12.5	13.8	14.0	13.5
900 001 - 1 100 000	11.2	11.1	11.3	11.5	12.7	12.3	12.1	12.3	8.6	8.7	9.8	10.0
1 100 001 - 1 600 000	16.2	18.7	19.6	19.8	19.3	21.5	22.2	22.5	10.6	13.1	14.6	14.6
1 600 001 - 2 100 000	6.3	7.4	10.0	8.9	7.8	8.8	12.1	10.5	3.4	4.9	6.0	5.8
2 100 001 - 3 000 000	3.8	4.9	6.7	5.3	4.8	6.2	8.5	6.3	2.0	2.6	3.2	3.5
3 000 001 төгрөгөөс дээш	2.1	2.5	3.5	2.7	2.8	3.0	4.6	3.4	0.9	1.4	1.2	1.2

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2021

Улсын хэмжээнд 2021 оны байдлаар сард дунджаар 300.0-500.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлого 410.4 мянган төгрөг буюу үүний 307.7 (75.0%) мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байна. Мөн сард дунджаар 1.1-1.6 сая төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлого 1.3 сая төгрөг буюу үүний 596.9 (44.7%) мянган төгрөгийг цалин хөлсний орлого, 484.6 (36.3%) мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байна (Хүснэгт 2.3, 2.4).

ХҮСНЭГТ 2.3 МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, төгрөгөөр, улсын дунджаар, оны үнээр, 2021 он

Мөнгөн орлогын бүлэг	Мөнгөн орлого	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	ХАА-н үйлдвэрлэлийн орлого	ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад орлого
300 000 төгрөг хүртэл	208 662	18 719	84 923	66 532	6 242	32 246
300 001 - 500 000	410 427	32 101	307 654	40 401	5 057	25 214
500 001 - 700 000	599 036	102 252	350 396	82 278	13 465	50 645
700 001 - 900 000	800 904	183 530	457 905	86 549	25 095	47 825
900 001 - 1 100 000	999 335	322 687	485 163	102 292	34 105	55 088
1 100 001 - 1 600 000	1 335 209	596 936	484 555	123 176	58 784	71 758
1 600 001 - 2 100 000	1 830 192	1 001 999	476 395	159 237	83 272	109 289
2 100 001 - 3 000 000	2 469 610	1 399 213	481 365	232 925	146 092	210 015
3 000 001 төгрөгөөс дээш	4 331 449	2 255 548	476 289	418 157	348 834	832 621

Эх үүсвэр: ӨНЭЗС 2021

ХҮСНЭГТ 2.4 МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар, улсын дунджаар, 2021 он

Мөнгөн орлогын бүлэг	Мөнгөн орлого					
		Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	ХАА-н үйлдвэрлэлийн орлого	ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад орлого
300 000 төгрөг хүртэл	100.0	9.0	40.7	31.9	3.0	15.4
300 001 - 500 000	100.0	7.8	75.0	9.9	1.2	6.1
500 001 - 700 000	100.0	17.1	58.5	13.7	2.3	8.4
700 001 - 900 000	100.0	22.9	57.2	10.8	3.1	6.0
900 001 - 1 100 000	100.0	32.3	48.6	10.2	3.4	5.5
1 100 001 - 1 600 000	100.0	44.7	36.3	9.2	4.4	5.4
1 600 001 - 2 100 000	100.0	54.7	26.0	8.7	4.6	6.0
2 100 001 - 3 000 000	100.0	56.7	19.5	9.4	5.9	8.5
3 000 001 төгрөгөөс дээш	100.0	52.1	11.0	9.7	8.0	19.2

Эх үүсвэр: ӨНЭЭС 2021

### III. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА

Өрхийн нийт зарлагыг өрхийн мөнгөн зарлага, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.

Өрхийн мөнгөн зарлага нь хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага, бусдад өгсөн бэлэг, тусламжаас бүрдэнэ.


#### 3.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА

Өрхийн сарын дундаж нийт зарлага оны үнээр 2021 онд 1.5 сая төгрөг болж, өмнөх оноос 20.2 (1.3%) мянган төгрөгөөр, (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт зарлагын хэмжээ 1.1 сая төгрөг болж, өмнөх оноос 158.5 (13.0%) мянган төгрөгөөр тус тус буурсан байна (Зураг 3.1а).

Улсын дунджаар нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2021 онд өмнөх оноос 0.6 нэгж хувиар, бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 0.6 нэгж хувиар буурч, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 1.2 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 3.1б).



ЗУРАГ 3.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, зарлагын бүтэц, дүнд эзлэх хувиар, улсын дунджаар



Өрхийн сарын дундаж нийт зарлага оны үнээр 2021 онд өмнөх оноос хотод 64.5 (4.0%) мянган төгрөгөөр буурч, харин хөдөөд 66.8 (5.0%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хотын нэг өрхийн сарын дундаж нийт зарлага хөдөөгийнхөөс 135.0 (9.6%) мянган төгрөгөөр илүү байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн зарлагын энэ зөрүү өмнөх оноос 131.3 мянган төгрөг буюу 10.2 нэгж хувиар буурсан байна. Үнийн нөлөөллийг арилган 2015 оны үнээр илэрхийлж үзэхэд өрхийн сарын дундаж бодит нийт зарлага 2021 онд өмнөх оноос хотод 198.4 (15.4%) мянган төгрөгөөр, хөдөөд 80.5 (7.5%) мянган төгрөгөөр буурсан байв (Зураг 3.2).

ЗУРАГ 3.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, хот, хөдөөгөөр



Өрхийн нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2021 онд өмнөх оноос хотод 0.6 нэгж хувиар өсөж, хөдөөд 2.0 нэгж хувиар буурсан байна. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.7 нэгж хувиар, хөдөөд 0.4 нэгж хувиар


буурсан бол өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.1 нэгж хувиар, хөдөөд 2.4 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 3.3).

ЗУРАГ 3.3 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, хот, хөдөөгөөр



Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага оны үнээр 2021 онд өмнөх оноос Баруун бүсэд 184.5 (12.3%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 102.1 (7.9%) мянган төгрөгөөр нэмэгдэж, Төвийн бүсэд 37.8 (2.8%) мянган төгрөгөөр буурсан бол Зүүн бүсэд бараг өөрчлөлтгүй байна. Харин бодит нийт зарлагын хэмжээ өмнөх оноос Төвийн бүсэд 156.5 (14.3%) мянган төгрөгөөр, Зүүн бүсэд 138.4 (11.7%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 50.6 (4.9%) мянган төгрөгөөр, Баруун бүсэд 12.0 (1.0%) мянган төгрөгөөр тус тус буурсан байна (Зураг 3.4).

ЗУРАГ 3.4 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, бүсээр




Нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2021 онд Баруун бүсэд хамгийн бага буюу 83.7 хувь, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хамгийн өндөр буюу 13.1 хувь байна (Зураг 3.5).

ЗУРАГ 3.5 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, бүсээр




Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага оны үнээр 2021 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 119.2 (7.1%) мянган төгрөгөөр буурч, харин аймгийн төвд 60.0 (4.1%) мянган төгрөгөөр, сумын төвд 80.1 (5.9%) мянган төгрөгөөр, хөдөөд 62.1 (4.7%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Харин бодит нийт зарлагын хэмжээ өмнөх оноос Улаанбаатар хотод 243.6 (18.1%) мянган төгрөгөөр, аймгийн төвд 95.6 (8.2%) мянган төгрөгөөр, сумын төвд 71.9 (6.6%) мянган төгрөгөөр, хөдөөд 82.7 (7.7%) мянган төгрөгөөр тус тус буурсан байв (Зураг 3.6).

ЗУРАГ 3.6 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, суурьшлаар



Өрхийн сарын дундаж нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь хөдөөд хамгийн бага буюу 78.7 хувь, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хамгийн өндөр буюу 19.3 хувь байна (Зураг 3.7).

ЗУРАГ 3.7 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, суурьшлаар



### 3.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага оны үнээр 2021 онд улсын дунджаар 1.4 сая төгрөг болж, өмнөх оноос 26.0 (1.9%) мянган төгрөгөөр буурсан байна. Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг задалбал, хүнсний зүйлийн зарлага оны үнээр өмнөх оноос 7.8 (2.6%) мянган төгрөгөөр, бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлага 2.2 (7.8%) мянган төгрөгөөр нэмэгдэж, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 36.0 (3.4%) мянган төгрөгөөр буурсан байна. Мөн өрхийн сарын дундаж бодит мөнгөн зарлагын хэмжээ 2021 онд 973.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 151.7 (13.5%) мянган төгрөгөөр буурсан байна. Бодит мөнгөн зарлагыг задалвал, хүнсний зүйлийн бодит зарлага өмнөх оноос 23.2 (9.6%) мянган төгрөгөөр, хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 127.4 (14.8%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 3.8).

ЗУРАГ 3.8 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, улсын дунджаар



Улсын дунджаар 2021 онд өрхийн сарын дундаж хүнсний зүйлийн зарлагын 35.0 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 23.5 хувийг үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн, 11.9 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, 7.7 хувийг хүнсний ногоо, булцуут, навчит ургамал, 3.7 хувийг элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан, 3.6 хувийг жимс, самар, 3.2 хувийг цэвэр ус, ундаа, жимсний шүүс эзэлж байна (Хүснэгт 3.1).

### ХҮСНЭГТ 3.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ХҮНСНИЙ ЗҮЙЛИЙН ЗАРЛАГА, төгрөгөөр, зарим нэр төрлөөр, улсын дунджаар

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	2018	2019	2020	2021
Мах, махан бүтээгдэхүүн	72 275	88 645	99 104	108 526
Үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн	63 106	67 121	73 079	72 779
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	27 031	27 499	34 015	36 989
Хүнсний ногоо, булцуут, навчит ургамал	19 152	20 961	23 355	23 925
Элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан	10 596	11 442	12 879	11 468
Жимс, самар	8 081	9 076	9 382	11 049
Цэвэр ус, ундаа, жимсний шүүс	7 981	8 462	11 751	10 006
Төрөл бүрийн өөх, тос	6 336	7 199	7 514	8 020
Цай, кофе	5 112	5 754	5 196	5 326

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2021

Өрхийн сарын дундаж хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 10.5 хувийг бэлэн хувцас, гутал, 8.4 хувийг тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээ, 5.4 хувийг харилцаа холбооны үйлчилгээ, 5.2 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ, 4.6 хувийг боловсролын үйлчилгээний зарлага эзэлж байна (Хүснэгт 3.2).

### ХҮСНЭГТ 3.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ХҮНСНИЙ БУС БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГА, төгрөгөөр, зарим нэр төрлөөр, улсын дунджаар

Хүнсний бус бараа, үйлчилгээний нэр төрөл	2018	2019	2020	2021
Тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээ	73 276	87 672	90 653	86 726
Бэлэн хувцас	75 512	89 254	73 086	71 256
Харилцаа холбооны үйлчилгээ	38 403	44 767	52 359	55 876
Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ	34 708	39 020	49 358	54 382
Боловсрол	39 767	41 410	45 200	47 606
Гутал, хос	32 666	37 954	39 135	37 003
Түлш	21 246	22 138	25 972	25 209
Чөлөөт цаг болон соёлын үйлчилгээ	21 908	26 569	26 196	24 224
Сууцны төлбөр	25 334	28 087	30 376	23 992
Цахилгаан	21 043	23 036	25 870	12 757

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2021

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага оны үнээр 2021 онд өмнөх оноос хотод 52.2 (3.4%) мянган төгрөгөөр буурч, харин хөдөөд 28.7 (2.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн зарлагыг хооронд нь харьцуулбал, оны үнээр 2021 онд хотын нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага хөдөөгийнхөөс 339.5 (29.4%) мянган төгрөгөөр илүү байна. Хот, хөдөөгийн өрхүүдийн зарлагын энэ зөрүү өмнөх оноос 80.9 мянган төгрөг буюу 7.9 нэгж хувиар буурсан байна. Үнийн нөлөөллийг арилган 2015 оны үнээр илэрхийлж үзэхэд өрхийн сарын дундаж бодит мөнгөн зарлага 2021 онд өмнөх оноос хотод 183.9 (14.8%) мянган төгрөгөөр, хөдөөд 86.8 (9.6%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 3.9).

ЗУРАГ 3.9 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, хот, хөдөөгөөр




Хотын өрх сарын дундаж мөнгөн зарлагынхаа 73.5 хувийг хүнсний бус бараа, үйлчилгээнд, 25.0 хувийг хүнсний зүйлд зарцуулж байгаа бол хөдөөгийн өрхийн хувьд хүнсний бус бараа, үйлчилгээнд 79.8 хувийг, хүнсний зүйлд 16.3 хувийг зарцуулж байна (Зураг 3.10).

ЗУРАГ 3.10 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, хот, хөдөөгөөр




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага оны үнээр 2021 онд өмнөх оноос Баруун бүсэд 121.0 (9.4%) мянган төгрөгөөр, Хангайн бүсэд 74.7 (6.5%) мянган төгрөгөөр нэмэгдэж, Төвийн бүсэд 48.2 (3.9%) мянган төгрөгөөр буурсан бол Зүүн бүсийн хувьд бараг өөрчлөлтгүй байна. Бодит мөнгөн зарлагын хэмжээ өмнөх оноос бүсүүдэд 36.7-150.0 (3.6%-15.3%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 3.11).

ЗУРАГ 3.11 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, бүсээр




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагад хүнсний зүйлийн зарлагын эзлэх хувь 2021 онд өмнөх оноос Баруун бүсэд 0.4 нэгж хувиар буурч, Хангайн бүсэд 0.1 нэгж хувиар, Төвийн бүсэд 1.8 нэгж хувиар нэмэгдсэн бол хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлагын эзлэх хувь өмнөх оноос бүсүүдэд 0.1-2.5 нэгж хувиар буурсан байна (Зураг 3.12).

ЗУРАГ 3.12 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, бүсээр



Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага оны үнээр 2021 онд өмнөх оноос Улаанбаатар хотод 96.7 (6.0%) мянган төгрөгөөр буурсан бол бусад суурьшилд 47.0-50.2 (3.6%-4.5%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Харин бодит мөнгөн зарлагын хэмжээ бүх суурьшилд буурсан байна (Зураг 3.13).

ЗУРАГ 3.13 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, суурьшлаар



Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагад хүнсний зүйлийн зарлагын эзлэх хувь 2021 онд өмнөх оноос хөдөөд 0.2 нэгж хувиар буурч, бусад суурьшилд 0.1-2.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын мөнгөн зарлагад эзлэх хувь бүх суурьшилд өмнөх оноос 0.6-2.3 нэгж хувиар буурсан байна (Зураг 3.14).

ЗУРАГ 3.14 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, суурьшлаар




Өрхийн амьдарч буй сууцны төрөл нь өрхийн хэрэглээний зардалд хэрхэн нөлөөлж буйг харуулахаар цахилгаан, түлш, сууцны төлбөр, тээврийн үйлчилгээ (хувийн зориулалттай тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар ороогүй), харилцаа холбооны зардлыг авч үзлээ. Харилцаа холбоо болон сууцны төлбөр орон сууцанд амьдардаг өрхийн хувьд хамгийн их, гэрт амьдардаг өрхийн хувьд хамгийн бага зардал нь байна. Түлшний зардал байшинд амьдардаг өрхийн хувьд хамгийн өндөр, цахилгааны зардал гэрт амьдардаг өрхийн хувьд хамгийн бага байна. Өрхийн амьдарч буй сууцны төрлөөс шалтгаалж харилцаа, холбоо, түлш, тээврийн үйлчилгээ, сууцны төлбөр, цахилгаандаа зарцуулж буй зардлууд нь харилцан адилгүй байгааг доорх зургаас харах боломжтой юм. Улсын дунджаар 2021 онд



нэг өрх сард дунджаар цахилгааны зардалд 12.8 мянган төгрөг, сууцны төлбөрт 24.0 мянган төгрөг, тээврийн үйлчилгээнд 24.2 мянган төгрөг, түлшинд 25.2 мянган төгрөг, харилцаа холбоонд 55.9 мянган төгрөгийг зарцуулсан байна (Зураг 3.15).

ЗУРАГ 3.15 ӨРХИЙН ЗАРИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ, мянган төгрөгөөр, сууцны төрлөөр, 2021 он



Улсын дунджаар 500.0 мянган төгрөг хүртэлх зарлагатай өрхийн эзлэх хувь 2021 онд өмнөх оноос 6.6 нэгж хувиар, 500.0-700.0 мянган төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 1.8 нэгж хувиар, 700.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 0.6 нэгж хувиар нэмэгдэж, харин 900.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 0.4 нэгж хувиар, 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 2.2 нэгж хувиар, 1.6-2.1 сая төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 2.7 нэгж хувиар, 2.1-3.0 сая төгрөгийн зарлагатай өрхийн эзлэх хувь 2.3 нэгж хувиар, 3.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрхийн эзлэх хувь 1.4 нэгж хувиар тус тус буурсан байна. Хотын нийт өрхийн 19.5 хувь, хөдөөгийн нийт өрхийн 35.8 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэлх зарлагатай, мөн хотын 19.7 хувь, хөдөөгийн 13.7 хувь нь 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай, хотын 15.8 хувь, хөдөөгийн 9.3 хувь нь 1.6 сая төгрөгөөс дээш зарлагатай өрхүүд байжээ (Хүснэгт 3.3).

ХҮСНЭГТ 3.3 МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

Мөнгөн зарлагын бүлэг	Улсын дундаж				Хот				Хөдөө			
	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
300 000 төгрөг хүртэл	9.2	6.0	5.9	8.3	5.5	3.5	3.0	5.2	16.0	10.8	11.3	14.3
300 001 - 500 000	16.8	14.3	12.6	16.8	14.4	11.8	9.6	14.3	21.1	19.2	18.4	21.5
500 001 - 700 000	16.3	16.3	15.8	17.6	15.5	15.5	14.8	17.0	17.7	17.8	17.8	18.6
700 001 - 900 000	14.7	14.2	13.8	14.4	15.3	14.1	13.8	15.0	13.4	14.3	13.7	13.3
900 001 - 1 100 000	11.1	11.8	12.1	11.7	11.9	12.8	12.7	13.0	9.8	9.9	10.9	9.3
1 100 001 - 1 600 000	17.3	19.4	19.8	17.6	19.6	21.3	22.0	19.7	13.2	15.7	15.6	13.7
1 600 001 - 2 100 000	7.6	9.5	10.3	7.6	9.0	10.9	12.0	8.7	5.1	6.9	7.1	5.5
2 100 001 - 3 000 000	5.0	6.3	6.4	4.1	6.2	7.4	8.0	4.7	2.6	4.2	3.5	2.8
3 000 001 төгрөгөөс дээш	2.0	2.2	3.3	1.9	2.6	2.7	4.1	2.4	1.1	1.2	1.7	1.0

Эх үүсвэр: ӨНЭЭС 2018-2021

Улсын хэмжээнд 2021 оны байдлаар сард дунджаар 300.0-500.0 мянган төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлага 409.1 мянган төгрөг буюу үүнийхээ 136.7 (33.4%) мянган

төгрөгийг хүнсний зүйлд, 263.5 (64.4%) мянган төгрөгийг хүнсний бус бараа, үйлчилгээндээ зарцуулж байна. Мөн сард дунджаар 1.1-1.6 сая төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлага 1.3 сая төгрөг буюу үүнийхээ 343.6 (25.9%) мянган төгрөгийг хүнсний зүйлд, 960.2 (72.2%) мянган төгрөгийг хүнсний бус бараа, үйлчилгээндээ зарцуулж байна (Хүснэгт 3.4, 3.5).

ХҮСНЭГТ 3.4 МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, төгрөгөөр, улсын дунджаар, оны үнээр, 2021 он

Мөнгөн зарлагын бүлэг	Мөнгөн зарлага	Хүснэгт 3.4		
		Хүнсний зүйлийн зарлага	Хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага	Бусдад өгсөн бэлэг, тусламж
300 000 төгрөг хүртэл	226 332	77 660	145 593	3 079
300 001 - 500 000	409 104	136 709	263 531	8 864
500 001 - 700 000	605 594	196 485	399 056	10 053
700 001 - 900 000	800 751	244 128	538 515	18 108
900 001 - 1 100 000	994 643	290 155	686 333	18 155
1 100 001 - 1 600 000	1 329 000	343 649	960 176	25 175
1 600 001 - 2 100 000	1 829 285	404 803	1 394 010	30 472
2 100 001 - 3 000 000	2 478 518	446 756	1 973 878	57 884
3 000 001 төгрөгөөс дээш	4 269 105	533 311	3 592 850	142 944

Эх үүсвэр: ӨНЭЭС 2021

ХҮСНЭГТ 3.5 МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц, дүнд эзлэх хувиар, улсын дунджаар, 2021 он

Мөнгөн зарлагын бүлэг	Мөнгөн зарлага	Хүснэгт 3.5		
		Хүнсний зүйлийн зарлага	Хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага	Бусдад өгсөн бэлэг, тусламж
300 000 төгрөг хүртэл	100.0	34.3	64.3	1.4
300 001 - 500 000	100.0	33.4	64.4	2.2
500 001 - 700 000	100.0	32.4	65.9	1.7
700 001 - 900 000	100.0	30.5	67.2	2.3
900 001 - 1 100 000	100.0	29.2	69.0	1.8
1 100 001 - 1 600 000	100.0	25.9	72.2	1.9
1 600 001 - 2 100 000	100.0	22.1	76.2	1.7
2 100 001 - 3 000 000	100.0	18.0	79.7	2.3
3 000 001 төгрөгөөс дээш	100.0	12.5	84.2	3.3

Эх үүсвэр: ӨНЭЭС 2021

## IV. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИН

### 4.1 ӨРХИЙН ОРЛОГО БА ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл бол өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлын талаарх үзүүлэлт юм. Өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдал өрхийн орлогод хэрхэн нөлөөлж буйг Зураг 4.1-д харууллаа. Өрхийн тэргүүн нь ажил


эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2021 онд 1.7 сая төгрөг болж, өмнөх оноос 156.0 (9.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй өрхийн сарын дундаж мөнгөн орлогоос 534.6 (44.4%) мянган төгрөгөөр, өрхийн тэргүүн нь ажиллах хүчнээс гадуур байдаг өрхөөс 629.1 (56.7%) мянган төгрөгөөр илүү байна.

ЗУРАГ 4.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, мянган төгрөгөөр, оны үнээр, өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар



Судалгааны 2021 оны дүнгээр өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 53.5 хувь нь цалин хөлсний орлого, 19.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 12.3 хувь нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, 6.4 хувь нь хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 8.1 хувь нь бусад орлогоос бүрдэж байна. Өрхийн тэргүүн нь ажиллах хүчнээс гадуур бол тухайн өрхийн орлогын хоёрны нэгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байна.

ЗУРАГ 4.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар



## 4.2 АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИНГИЙН ОРЛОГО

Улсын дунджаар 2021 онд нэг өрхийн сарын дундаж цалингийн орлого 694.6 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 59.9 (7.9%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж цалингийн орлого 2021 онд 929.2 мянган төгрөг байна. Ажил эрхэлдэг салбараар нь авч үзвэл, өрхийн тэргүүлэгч нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа өрхийн цалингийн дундаж орлогын хэмжээ хамгийн бага, харин аж үйлдвэрийн салбарт ажилладаг өрхийн тэргүүнтэй өрхийн цалингийн дундаж орлогын хэмжээ хамгийн өндөр байна. Өрхийн сарын дундаж цалингийн орлогын голч хэмжээ дундаж хэмжээтэйгээ харьцуулахад 137.6-244.6 мянган төгрөгөөр бага байгаа нь өрхийн цалингийн орлогын тархалт жигд биш буюу өндөр цалинтай хүн цөөн, бага цалинтай хүн олон байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл 2021 оны байдлаар нийт өрхийн 50 хувь нь 450.0 мянган төгрөгөөс бага цалингийн орлоготой, өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхийн тал хувь нь 770.0 мянган төгрөгөөс доош цалингийн орлоготой байна (Хүснэгт 4.1).

ХҮСНЭГТ 4.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ОРЛОГО, төгрөгөөр, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхэлдэг салбараар

	Өрхийн сарын дундаж цалингийн орлого				Өрхийн сарын дундаж цалингийн орлогын голч			
	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
Улсын дундаж	577 813	678 901	754 492	694 576	400 000	450 000	500 000	450 000
Ажилтай: Нийт	720 924	842 036	961 806	929 244	570 000	680 000	800 000	770 000
Хөдөө аж ахуй	125 820	135 681	153 629	137 552	-	-	-	-
Аж үйлдвэр	1 041 206	1 230 539	1 431 393	1 469 733	900 000	1 040 000	1 220 000	1 250 000
Үйлчилгээ	847 955	974 925	1 098 920	1 144 662	700 000	800 000	980 000	1 000 000


Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2021

## V. ТЭГШ БУС БАЙДАЛ

### 5.1 ОРЛОГЫН ТЭГШ БУС БАЙДАЛ


Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр хувааж үзвэл, хамгийн бага орлоготой бүлгийн өрхүүдийн дундаж мөнгөн орлого улсын дундаж мөнгөн орлогоос 3.1 дахин бага, хамгийн их орлоготой бүлгийн өрхүүдийн дундаж мөнгөн орлого 2.1 дахин их байна. Хамгийн их орлоготой бүлгийн өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлого хамгийн бага орлоготой бүлгийнхээс 6.6 дахин их байна. Өрхийн орлого нэмэгдэх тусам орлого өндөртэй бүлгүүдийн хувьд цалингийн орлогын эзлэх хувь өсөж байна (Зураг 5.1).

ЗУРАГ 5.1 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, мянган төгрөгөөр, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, 2021 он



Хамгийн бага орлоготой бүлгийн өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлогын гуравны хоёрыг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байхад хамгийн их орлоготой бүлгийн өрхүүдийн хувьд сарын дундаж мөнгөн орлогынх нь зургааны нэг хүрэхгүй хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж байна. Эндээс харахад бага орлоготой өрхүүдийн амьжиргаанд тэтгэвэр, тэтгэмжийн орлогын үзүүлэх нөлөө их байдаг нь харагдаж байна (Зураг 5.2).


ЗУРАГ 5.2 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, 2021 он



## 5.2 ЗАРЛАГЫН ТЭГШ БУС БАЙДАЛ


Хамгийн бага зарлагатай 20 хувийн өрхүүдийн дундаж мөнгөн зарлага улсын дунджаас 3.1 дахин бага, хамгийн их зарлагатай 20 хувийнхны дундаж мөнгөн зарлага 2.1 дахин их байна. Хамгийн их зарлагатай бүлгийн сарын дундаж мөнгөн зарлага хамгийн бага зарлагатай бүлгийнхээс 6.6 дахин их байна (Зураг 5.3).

ЗУРАГ 5.3 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, мянган төгрөгөөр, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, 2021 он



Хамгийн бага зарлагатай бүлгийн өрхүүд сарын дундаж мөнгөн зарлагынхаа гуравны нэгийг хүнсний зүйлд зарцуулж байхад хамгийн их зарлагатай бүлгийн өрхүүд сарын дундаж мөнгөн зарлагынхаа зургааны нэгийг хүнсний зүйлдээ зарцуулж байна (Зураг 5.4).

ЗУРАГ 5.4 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, 2021 он




Өрхийн сарын дундаж хүнсний зүйлийн зарлагыг задалж, зарим нэр төрлийг авч үзэхэд хамгийн бага зарлагатай бүлгийн өрхүүдийн хүнсний зарлагын 63.0 хувийг мах, махан бүтээгдэхүүн, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байна. Хамгийн зарлага өндөртэй бүлгийн өрхүүд мах, махан бүтээгдэхүүн, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүнд хүнсний нийт зарлагынхаа 54.0 хувийг зарцуулж буй боловч мөнгөн дүнгээрээ хамгийн бага зарлагатай бүлгийнхээс дунджаар 2.7 дахин их мөнгө зарцуулж байна (Зураг 5.5).

ЗУРАГ 5.5 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ХҮНСНИЙ ЗҮЙЛИЙН ЗАРЛАГА, төгрөгөөр, зарим нэр төрлөөр, хамгийн бага болон хамгийн их зарлагатай бүлгээр, 2021 он



Мөн өрхийн сарын дундаж хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагыг задалж, зарим нэр төрлийг авч үзэхэд хамгийн бага зарлагатай бүлгийн өрхүүд гутал, хувцас худалдан авахад хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагынхаа 15.4 хувийг зарцуулж байгаа боловч мөнгөн дүнгээр авч үзвэл хамгийн зарлага өндөртэй бүлгийнхээс 4.2 дахин бага байна. Хамгийн зарлага өндөртэй бүлгийн өрхүүдийн эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний дундаж зарлага хамгийн бага зарлагатай бүлгийнхээс 3.2 дахин их, тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээний дундаж зарлага 8.6 дахин их боловч хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагад эзлэх хувийн жин нь 0.3 нэгж хувиар л илүү байна. Хамгийн зарлага өндөртэй бүлгийн өрхүүд түлшиндээ хамгийн бага зарлагатай бүлгийнхтэй ойролцоо зарлага гаргадаг боловч нийт хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагад эзлэх хувийн жин нь хамгийн бага зарлагатай бүлгийнх 6.7 нэгж хувиар илүү байна (Зураг 5.6).

ЗУРАГ 5.6 ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ХҮНСНИЙ БУС БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГА төгрөгөөр, зарим нэр төрлөөр, хамгийн бага болон хамгийн их зарлагатай бүлгээр, 2021 он



## VI. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

### 6.1 ХАДГАЛАМЖ

Өрхийн санхүүгийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь хуримтлал билээ. Өрхийн орлого нь зарлагаа давж байвал хүмүүс хуримтлуулдаг, харин өдөр тутмын хэрэгцээнд дөнгөж хүрэлцэх төдий орлоготой бол хадгаламж үүсгэх боломжгүй байдаг. Судалгааны 2021 оны дүнгээр улсын хэмжээнд нийт өрхийн 37.1 хувь нь хадгаламжтай байгаа нь өмнөх оноос 5.2 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 6.1 ХАДГАЛАМЖТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ




Хадгаламжтай өрхийн эзлэх хувь 2021 онд хөдөөд хотынхоос 1.0 нэгж хувиар бага байна. Хот, хөдөөд аль алинд нь (хотод 5.9 нэгж хувь, хөдөөд 3.9 нэгж хувь) хадгаламжтай өрхийн эзлэх хувь өмнөх оноос нэмэгджээ.



## 6.2 ЗЭЭЛ

Өрхүүд санхүүгийн хэрэгцээгээ хангахын тулд албан болон албан бус эх үүсвэрээс зээл авч байна. Судалгааны 2021 оны дүнгээр улсын хэмжээнд нийт өрхийн 52.1 хувь нь ямар нэгэн<sup>2</sup> зээлтэй амьдарч байгаа нь өмнөх оноос 7.3 нэгж хувиар буурсан байна. Нийт зээлтэй өрхийг зээлийн төрлөөр нь авч үзэхэд 43.5 хувь нь цалингийн зээлтэй, 15.7 хувь нь орон сууцны зээлтэй, 10.4 хувь нь тэтгэврийн зээлтэй, 9.4 хувь нь хэрэглээний зээлтэй, 6.7 хувь нь автомашины зээлтэй байна (Зураг 6.2).


ЗУРАГ 6.2 ЗЭЭЛТЭЙ ӨРХ, зээлийн төрлөөр, улсын дунджаар



Нэг өрх хэд хэдэн зээлтэй байх тохиолдол нэлээдгүй байна. Тухайлбал, тухайн өрхөд ажил хийдэг хоёр хүн хоёулаа цалингийн зээлтэй байх, тэтгэврийн хоёр ахмад настан хоёулаа тэтгэврийн зээлтэй байх, эсвэл өрхийн нэг гишүүн нь цалингийн зээлтэй байхад нөгөөх нь лизингийн зээлтэй байх гэх мэт олон тохиолдлууд байна. Зээлийн давхцалыг тооцохдоо өрхөд ижил төрлийн зээл олон байгаа тохиолдолд нэг зээл болгон нэгтгэж авсан бөгөөд өөр төрлийн зээл байгаа тохиолдолд давхар зээлтэй гэж үзсэн. Дараах зурагт өрхийн 3 хүртэлх төрлийн зээлийн давхцалыг харууллаа.

Судалгааны 2021 оны дүнгээр зээлтэй өрхүүдийн 78.5 хувь нь зөвхөн нэг төрлийн зээлтэй, 18.1 хувь нь 2 төрлийн зээлтэй, 3.4 хувь нь 3 төрлийн давхар зээлтэй байна (Зураг 6.3).

ЗУРАГ 6.3 ЗЭЭЛИЙН ДАВХЦАЛ, хувиар



<sup>2</sup> Өрхийг хэдэн төрлийн зээлтэй байхаас нь үл хамааруулан ямар нэгэн зээлтэй бол тухайн өрхийг зээлтэй өрх гэж тооцсон.

Зээлтэй өрхүүдийн сүүлийн 12 сард авсан зээлийн дундаж хэмжээг доорх хүснэгтэд харуулж байна. Зээлтэй нэг өрх 2021 онд дунджаар 9.3 сая төгрөгийн зээл авчээ. Зээлийн төрлөөр нь харвал, орон сууцны зээлийн дундаж хэмжээ өмнөх оноос 20.6 (53.0%) сая төгрөгөөр, бизнесийн зээлийн дундаж хэмжээ 10.7 (64.8%) сая төгрөгөөр, автомашины зээлийн дундаж хэмжээ 1.3 (8.8%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна (Хүснэгт 6.1).

ХҮСНЭГТ 6.1 СҮҮЛИЙН 12 САРЫН ХУГАЦААНД АВСАН ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сая төгрөгөөр, улсын дунджаар

Зээлийн төрөл	2018	2019	2020	2021
<b>Дундаж</b>	<b>6.8</b>	<b>7.6</b>	<b>7.9</b>	<b>9.3</b>
Орон сууцны	41.7	45.2	38.9	59.5
Бизнесийн	14.2	19.8	16.5	27.2
Автомашины	15.3	13.7	14.8	16.1
Цалингийн	6.7	7.4	7.3	7.2
Өрхийн хэрэглээний	4.5	4.4	4.8	4.8
Лизингийн	2.5	2.9	2.2	2.7
Тэтгэврийн	3.3	3.5	2.3	2.1

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2021

Зээлтэй нэг өрх 2021 онд сард дунджаар 698.1 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтөд өгч байгаа нь өмнөх оноос 88.9 (14.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Орон сууцны зээлтэй өрх уг зээлэндээ сард дунджаар 687.3 мянган төгрөг, цалингийн зээлтэй өрх 494.4 мянган төгрөг, тэтгэврийн зээлтэй өрх 320.8 мянган төгрөгийг эргэн төлдөг байна (Хүснэгт 6.2).

ХҮСНЭГТ 6.2 ЗЭЭЛИЙН НЭГ САРЫН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, мянган төгрөгөөр, улсын дунджаар

Зээлийн төрөл	2018	2019	2020	2021
<b>Дундаж</b>	<b>508.1</b>	<b>548.8</b>	<b>609.2</b>	<b>698.1</b>
Бизнесийн	890.8	1 012.6	943.1	1 326.8
Орон сууцны	560.8	548.1	583.1	687.3
Автомашины	683.6	615.6	548.5	601.5
Цалингийн	408.2	440.5	469.3	494.4
Өрхийн хэрэглээний	315.9	333.5	348.3	348.7
Тэтгэврийн	330.7	336.0	310.9	320.8
Лизингийн	148.5	194.6	158.8	187.9

Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2021

.....ооо.....